

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ  
ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН  
БҮСИЙН ЗАХИРГААНЫ ЗАХИРАЛ  
Б.ОРГИЛ ТАНАА

2019.02.25 № 06/319  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус захиргааны захирал Б.Оргил танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 18-наас 2019 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Санхүүч-аудит” ХХК-ийн аудитор Д.Ариунаа, Б.Энхсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс нь Дорнод аймгийн Халх гол сумын нутагт байрлах “Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс” улсын хэрэгцээний газарт эрчимжсэн мал аж ахуй газар тариалангийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг хөгжүүлэх, төрөөс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мал аж ахуй газар тариалангийн бүтээгдхүүний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг бий болгон зах зээлийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдхүүний үйлдвэрлэл борлуулалтыг нэмэгдүүлэх, мал аж ахуй болон газар тариалангийн үйлдвэрлэл явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь дээрх эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл:

- Эрчимжсэн мал аж ахуйг нэвтрүүлэх, газар тариалангийн бүтээгдхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж өртгийн сүлжээ бий болгох, мал аж ахуй, агро аялал жуулчлал, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах.
- Мал аж ахуй, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид болон тус бүсэд үйл ажиллагаагаа явуулах иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх.

- Гадаадын орнуудын болон дотоодын мал аж ахуй, газар тариалангийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан судалгаа хийх, судалгааны үндсэн дээр зорилтот хэрэглэгчидтэй экспорт, импортын худалдааны гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахад оролцох.
- Олон улсын зах зээлд Монголын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний брэндийг бий болгоход дэмжлэг үзүүлж ажиллах.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамж ашигладаг байна.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус бүсийн захиргаа нь төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлдэг байгууллага учир нийт зардлыг суурь болгох нь зүйтэй гэж үзэв.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны нийт зардал 294,930.0 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 2,949.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.



Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал:

№	Шийдэл	/мянган төгрөгөөр/		
		Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж	1	0.0	
	Дүн	1	0.0	

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайлан 3,120.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийв.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Халх гол төслийн хүрээнд БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Дорнод аймгийн Халх гол сумын 200 га талбайд “Мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар аж ахуй”-г байгуулсан байна. ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-161 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг дээрх загвар аж ахуйн өмч хөрөнгийг бүртгэн авч, 2,400,754.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 150,670.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл зэрэг хөрөнгийг тус бүсийн захиргааны харьяанд шилжүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд Монгол улсад санхүүгийн тайлагналын /СТОУС/ болон улсын секторын олон улсын стандартыг мөрдөхөөр заасан бөгөөд “СТОУС-16-ийн 32 дугаар зүйлд “... хөрөнгийн бодит үнэд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан бол жил бүр, үл мэдэгдэм өөрчлөлттэй бол 3-5 жил тутам үнэлгээ хийх нь тохиромжтой” гэж заасан. Уг стандартын дагуу тус бүсийн захиргаа нь ашиглалтад ороод удаагүй байгаа дээрх барилга байгууламжийн дахин үнэлгээг хийгээгүй байна.

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 403,299.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тус бүсийн захиргаа нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 403,299.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 164,251.6 мянган төгрөг нийт 567,550.7 мянган төгрөгийн

санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 401,600.8 мянган төгрөг зарцуулж, 165,949.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 70.7 хувийн биелэлттэй байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

УИХ-ын 2016 оны 46 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулахаар шийдвэрлэсэн байна. Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолоор бүсийн захиргааг байгуулан 500.0 мянган га газрыг “Улсын тусгай хэрэгцээнд” авч хилийн заагийг тогтоожээ.

Гэвч дараах хүчин зүйлээс шалтгаалан бүсийн тусгай хэрэгцээний газрыг аж ахуйн эргэлтэд оруулах, үндэсний бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх ажил удааширсан байна.

1. Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдөр “гэрээ байгуулах тухай” А-01 тоот тушаал гаргаж, Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн тусгай хэрэгцээний газрын 63.5 хувь буюу 317,675.624 га газрыг хууль зөрчин сонгон шалгаруулалтгүйгээр голчлон газар тариалангийн зориулалтаар 24 аж ахуйн нэгжид олгосон байна.
2. Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлын 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Тушаал хүчингүй болгох тухай” А-01 тоот тушаалыг гаргаж өмнөх удирдлагын шийдвэрийг цуцалсан байна.  
Аж ахуйн нэгжүүдээс газрын төлбөрт төлсөн төлбөрөөс 2016 онд 389,087.9 мянган төгрөг, 2017 онд 118,729.3 мянган төгрөг буцаан төлж, 3 аж ахуйн нэгж 164,201.5 мянган төгрөгийг шүүхээр хэрэг эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл авахгүй гэж буцааж аваагүйгээс тус бүсийн захиргааны тайлан тэнцэлд өглөгөөр бүртгэлтэй байна.

Дээрх цуцалсан шийдвэрийг эсэргүүцэж нэр бүхий 12 аж ахуйн нэгж бүсийн захиргааны захирлын 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/01 тоот тушаалыг хүчингүй болгуулах гомдыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр гаргаж, шүүхээс тушаалын хэрэгжилтийг түдгэлзүүлсэн байна.

Мөн Халх гол сумын Засаг даргын орлогчоор ажиллаж байсан Л.Энх-Амгалан нь захирамж гарган газар тариалангийн 4 компаний 31,887.9 га газрыг тусгай хэрэгцээний бүсийн газарт шилжүүлэн олгосон бол Засаг даргаар ажиллаж байсан В.Мөнхтайваны захирамжаар тухайн жилийн ургацын байдлыг харгалзан ашиглахаар 4 аж ахуй нэгж, 1 иргэнд 50000 га хадлангийн газрыг 10-15 жилийн хугацаатайгаар мөн бүсийн нутаг дэвсгэрт олгожээ.

Тус бүсийн захиргаанаас эдгээр захирамжийг хүчингүй болгуулах хүсэлтийг журмын дагуу дээд шатны Засаг даргад албан бичгээр тавьсан боловч одоогоор шийдэгдээгүй, мөн шүүх хуралдаан 24 удаа зарлагдсан ч нэхэмжлэгчдийн зүгээс нотлох баримт нэмж гаргуулах, өмгөөлөгч болон шүүгчээс татгалзах зэргээр хуралдуулаагүй байна.

Эдгээр газрын маргаантай асуудлуудаас шалтгаалан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

### 3.1.2 Эрсдэл:

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийг байгуулж ажиллуулахтай холбон гарсан УИХ-ын 2016 оны 46, Засгийн газрын 2016 оны 328, 187, 2018 оны 109 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлэхгүй хууль, тогтоомж зөрчигдөж байна.

### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн улсын тусгай хэрэгцээний газрын тухай асуудлыг холбогдох газарт хандан шийдвэрлүүлж, Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу газрын дахин үнэлгээ хийлгэж, санхүүгийн тайланд тусгах.

### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг Халх гол сумын удирдлагууд дур мэдэн захиран зарцуулах зэргээр хууль зөрчиж байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>210,560,253.71</u></b>	<b><u>629,877,588.95</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	166,222,203.00	69,119,772.49
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,020,597.00	3,586,595.06
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	164,201,606.00	165,533,177.43
3351	Байгууллагаас авах авлага	164,201,606.00	165,533,177.43
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	44,338,050.71	460,757,816.46
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>		404,175,375.75
35110	Тусгай зориулалттай материал		404,175,375.75
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,088,050.00	6,442,440.00
35410	Бичиг хэргийн материал	288,050.00	2,042,440.00
35420	Аж ахуйн материал		400,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,800,000.00	4,000,000.00
35600	Мал амьтад	39,250,000.71	50,140,000.71
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,021,568,332.63</u></b>	<b><u>1,822,633,117.25</u></b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,021,568,332.63	1,822,633,117.25
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,021,568,332.63	1,822,633,117.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,400,754,673.00	2,400,754,673.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-715,148,280.77	-852,502,675.13
39203	Авто-тээврийн хэрэгсэл	150,670,407.00	193,670,407.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-50,353,471.11	-103,279,151.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	445,309,539.12	479,482,139.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	-217,300,367.94	-312,266,908.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,700,000.00	30,264,250.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64,166.67	-16,002,951.01
39214	Бусад үндсэн хөрөнгө		3,120,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-606,666.69
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Програм хангамж		770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-770,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,232,128,586.34</u></b>	<b><u>2,452,510,706.20</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>164,201,606.00</u></b>	<b><u>164,201,606.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	164,201,606.00	164,201,606.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	164,201,606.00	164,201,606.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	164,201,606.00	164,201,606.00
41361	Байгууллагад төлөх өглөг	164,201,606.00	164,201,606.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,067,926,980.34</u></b>	<b><u>2,288,309,100.20</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,067,926,980.34	2,288,309,100.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,067,926,980.34	2,288,309,100.20
51210	Өмнөх үеийн үр дүн	2,067,926,980.34	2,067,926,980.34
51220	Тайлант үеийн үр дүн		220,382,119.86
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,232,128,586.34</u></b>	<b><u>2,452,510,706.20</u></b>

#### 4.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>196,458,700.00</b>	<b>838,918,648.79</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>435,619,548.79</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	435,619,548.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	435,619,548.79
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,381,571.43
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		434,237,977.36
<b>124</b>	<b>Зээлийн орлого</b>	-	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>196,458,700.00</b>	<b>403,299,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	196,458,700.00	403,299,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,458,700.00	403,299,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>110,670,835.63</b>	<b>618,536,528.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>110,670,835.63</b>	<b>618,536,528.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	110,670,835.63	602,988,096.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	77,063,423.00	-
210101	Үндсэн цалин	77,063,423.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,464,502.63	-
210201	Тэтгэврийн даатгал	10,566,776.78	
210202	Тэтгэмжийн даатгал	404,713.85	
210203	ҮОМШӨ-ний даатгал	466,566.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	93,314.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	933,132.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	514,351.00
210301	Гэрэл, цахилгаан		514,351.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,356,460.00	21,210,210.00
210401	Бичиг хэрэг	729,500.00	4,105,610.00
210402	Тээвэр, шатахуун	2,580,600.00	13,127,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,046,360.00	3,977,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	15,727,050.00	26,585,885.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	15,727,050.00	26,585,885.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,059,400.00	332,929,834.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	339,300.00	331,822,362.00
210803	Даатгалын үйлчилгээ	337,500.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	360,600.00	947,642.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	221,747,816.99

ХАА-н Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		221,747,816.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	15,548,431.94
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	13,800,133.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		4,991,533.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		8,808,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	1,748,298.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,748,298.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>85,787,864.37</b>	<b>220,382,119.86</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>85,787,864.37</b>	<b>220,382,119.86</b>

### 4.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>360,660,306.00</b>	<b>567,550,706.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>164,201,606.00</b>	<b>164,251,606.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	164,201,606.00	164,251,606.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,201,606.00	164,251,606.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	164,201,606.00	164,251,606.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>196,458,700.00</b>	<b>403,299,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	196,458,700.00	403,299,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,458,700.00	403,299,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>111,210,835.63</b>	<b>564,430,706.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>111,210,835.63</b>	<b>564,430,706.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>111,210,835.63</b>	<b>384,680,668.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	78,942,790.85	-
210101	Үндсэн цалин	78,942,790.85	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10,585,134.78	-
210201	Тэтгэврийн даатгал	10,585,134.78	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	514,351.00
210301	Гэрэл, цахилгаан		514,351.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,896,460.00	22,164,600.00
210401	Бичиг хэрэг	1,269,500.00	5,860,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,580,600.00	12,327,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,046,360.00	3,977,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	15,727,050.00	26,585,885.00
210702	Дотоод албан томилолт	15,727,050.00	26,585,885.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,059,400.00	335,415,832.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	339,300.00	334,308,360.06
210803	Даатгалын үйлчилгээ	337,500.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	360,600.00	947,642.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>179,750,037.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	13,800,133.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		4,991,533.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		8,808,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	165,949,904.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		165,949,904.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>249,449,470.37</b>	<b>3,120,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>3,120,000.00</b>



ХАА-н Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>3,120,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	3,120,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		3,120,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-	<b>-3,120,000.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	249,449,470.37	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 4.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>			1,982,139,115.97	1,982,139,115.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>1,982,139,115.97</b>	<b>1,982,139,115.97</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			85,787,864.37	-
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>2,067,926,980.34</b>	2,067,926,980.34
D01	<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>2,067,926,980.34</b>	2,067,926,980.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>2,067,926,980.34</b>	2,067,926,980.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			220,382,119.86	220,382,119.86
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>2,288,309,100.20</b>	2,288,309,100.20

#### 4.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Хэтрэлт, хэмнэлт	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	403,299,100.00	567,550,706.00	-164,251,606.00	99.58
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	403,299,100.00	567,550,706.00	-164,251,606.00	99.58
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	389,490,500.00	387,800,668.06	1,689,831.94	99.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-	-	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,085,500.00	514,351.00	571,149.00	47.38
210301	Гэрэл, цахилгаан	1,085,500.00	514,351.00	571,149.00	47.38
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,164,600.00	22,164,600.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	5,860,000.00	5,860,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	12,327,200.00	12,327,200.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,977,400.00	3,977,400.00	-	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	26,585,900.00	26,585,900.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	26,585,900.00	26,585,900.00	-	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	339,654,500.00	338,535,832.06	1,118,667.94	99.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	337,500,200.00	337,428,360.00	71,840.00	99.98
210803	Даатгалын үйлчилгээ	990,000.00	115,830.00	874,170.00	11.70
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,076,300.00	947,642.00	128,658.00	88.05
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	44,000.00	44,000.00	50.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,808,000.00	13,800,133.00	7,867.00	
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,808,600.00	13,800,133.00	8,467.00	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	4,991,533.00	8,467.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,808,600.00	8,808,600.00	-	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	403,299,100.00	567,550,706.00	-164,251,606.00	99.58
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	403,299,100.00	403,299,100.00	1,748,298.94	99.57
131001	Улсын төсвөөс санхүүжих	403,299,100.00	403,299,100.00	1,748,298.94	99.57
131002	Төвлөрүүлэх шилжүүлэг		164,251,606.00	-164,251,606.00	
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	50,000.00	-50,000.00	
1200041	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		50,000.00	-50,000.00	
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22	21	1.00	95.45
620001	Удирдах ажилтан	6	5	1.00	83.33
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100.00

**5. АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

Огноо:	Аудитын нэр:	<b>ХАА-н Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2018 оны санхүүгийн тайлангийн аудит</b>	Аудитын код:
<b>2018.12.31</b>			<b>САГ-2019/128/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:		<b>ХАА-н Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа</b>	/мянган төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	УИХ-ын 2016 оны 46, Засгийн газрын 2016 оны 328, 187, 2018 оны 109 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал	Ж.Энхжаргал
	<b>Дүн</b>	-			